-улсын онц чухал объектыг хамгаалах;

-хөнөөх хэрэгслийн хөнөөл, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрийн ослын аюулаас хүн ам, эд баялгийг хамгаалахад туслах;

-дайчилгааны нөөцийг бүрдүүлж, хүн амыг цэргийн хэрэгт сургах;

-хүмүүнлэгийн үйл ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлэх;

-Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах хүчний хүрээнд үүрэг гүйцэтгэх, хуулиар тогтоосон бусад үүрэг гүйцэтгэх.

Зэвсэгт хүчин нь болзошгүй зэвсэгт түрэмгийллийг саатуулан няцаах үүргээ биелүүлэхэд шаардагдах бэлтгэлийг тайван цагт хангасан байна.

Монгол Улс гадны зэвсэгт түрэмгийлэлд өртвөл түүнийг саатуулан няцаах, өөрийгөө хамгаалах зэвсэгт тэмцлийг бүх хүч хэрэгсэл, боломжийг нэгтгэн дайчилж, ард иргэдийн дэмжлэг оролцоонд тулгуурлан явуулна. Тэгэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу бусад улс орон, олон улсын байгууллагын туслалцаа дэмжлэгийг авч болно.

Болзошгүй зэвсэгт түрэмгийллийг няцаахад зэвсэгт хүчнийг дараахь чиглэлээр бэлтгэнэ. Үүнд:

-зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, мэргэжлийн чиг баримжаатай анги салбарын тоог нэмэгдүүлж, чадавхыг дээшлүүлэх;

-улс орны зах зээлийн эдийн засгийн харилцаа, цэргийн гүйцэтгэх үүргийн онцлогт зохицсон нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны тогтолцоог бий болгох;

-цэргийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох, цэргийн удирдах болон мэргэжлийн боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх;

-батлан хамгаалах салбарт шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, мэдээллийн найдвартай

гтолцоог бүрдүүлэх, цэргийн шинжлэх ухаан, үндэсний ргийн урлагийг хөгжүүлэх;

- дэлхий дахины болон бүс нутгийн улс орнуудын рэг-улс төрийн бодлого, цэргийн хэрэгт гарч буй рчлөлт, хөгжилт, орон нутгийн дайн, мөргөлдөөн, хил агаалалтын сургамжийг судалж, дүгнэлт хийн, цэргийн э бүрэлдэхүүний нөхөн хангалтын журам, цэргийн алба ах хэлбэрийг боловсронгуй болгох.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 73 | Улаанбаатар хот |

### Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол сын Их Хурлаас ТОГТООХ нь:

Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.2, 3.1.13, 3.1.15. 1.8 дахь заалтад Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ьсан хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 74 | Улаанбаатар хот |

### Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 26 дугаар йлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТООХ нь:

Ариун цэврийн тухай хуулийн 7.1 дэх хэсэгт Монгол Улсын өнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 75 | Улаанбаатар хот |

**Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 53 дуга тойрогт 1998 оны 7 дугаар сарын 5-ны өдөр явагдс нөхөн сонгуулийн нэгдсэн дүнгийн тухай Сонгуули ерөнхий хорооны илтгэлийг хэлэлцээд Монгол Улсын Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдс Дэржээгийн Цэвээнжавын бүрэн эрхийг хүлээн зөвшөө сугэй.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 76 | Улаанбаатар хот |

**Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 04 тоот дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуули 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Нүүрсний уурхайнуудын лицензийг шинэчлэн олгс тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 12 дугі сарын 3-ны өдрийн 235 дугаар тогтоол Монгол Улс Үндсэн хуулийн дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгі заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэц 1998 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 04 тс дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 7 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 77 | Улаанбаатар хот

**Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 05 тоот дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Хурлаас ТОГТООХ нь:

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тоох тухай Улсын Их Хурлын 1996 оны 4 дүгээр сарын -ны өдрийн 24 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн улийн тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Засаг хиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг ийн засгийн бүтэц,хүн амын байршлыг харгалзан хайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Хурал шийдвэрлэнэ", мөн хуулийн тавин наймдугаар үлийн 1 дэх хэсгийн "Аймаг, нийслэл, сум, дүүрэг н хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн рдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн", мөн зүйлийн 2 дахь эгийн "Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг эгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал талина" гэсэн заалтуудыг тус тус зөрчөөгүй байна сэн Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 05 тоот гнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 7 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 78 | Улаанбаатар хот

**Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 06 тоот дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Хурлаас ТОГТООХ нь:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгч дийн хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаа зүйлийн 1, 3 дахь хэсгийн "... иргэдийн Төлөөлөгчдий Хурлын төлөөлөгч нас барсан, хүсэлтээрээ чөлөөлөгд сөн, эгүүлэн татсан бол Хурлын төлөөлөгчдий бүрэлдэхүүн гуравны хоёрт хүрэхгүй тохиолдолд нөхө сонгууль явуулна" гэсэн заалт Үндсэн хуулийн 3 дугаа зүйлийн 1, 16 дугаар зүйлийн 9, 14 дүгээр зүйлийн дэх хэсгийн заалтуудыг зөрчөөгүй байна гэсэн Үндсэ хуулийн цэцийн 1998 оны 06 тоот дүгнэлтийг хүлээ зөвшөөрсүгэй.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1998 оны 7 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 79 | Улаанбаатар хот

**Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн жаран тавдугаа зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлы хуралдааны дэгийн хуулийн 23 дугаар зүйлийн 3 дах хэсэг болон нууц санал хураалтын дүнг үндэслэн Монго Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санал болгосс Наваанпэрэнлэйн Жанцан, Улсын Их Хурлаас сана болгосон Дамбадаржаагийн Чилхаажав нарыг Монгол Улс Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2.Н.Жанцанг Үндсэн хуулийн цэцийн орон тооь гишүүнээр томилон ажиллуулсугай.

3.Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Совд, П.Баасан Ж.Бямбаа нарыг дараагийн гишүүдийг томилох хүртэл хугацаанд бүрэн эрхээ үргэлжлүүлж байхаа тогтоосугай.

ДАРГА Р.ГОНЧИ РЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 7 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 80 | Улаанбаатар хот

### Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

"Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хай", "Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, рчлөлт оруулах тухай", "Дээд боловсролын тухай ульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулиуд тлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ГТООХ нь:

1.Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн зар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай:

1/"Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт уулах тухай", "Бага, дунд боловсролын тухай хуульд мэлт, өөрчлөлт оруулах тухай", "Дээд боловсролын хай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" улиудийн дагуу холбогдох дүрэм, журмыг батлан ргах, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тогтоол, йдвэр, дүрэм, журмыг эдгээр хуулиудтай нийцүүлэх, рийн бус өмчийн ангийн төлөө бүх шатны сургууль, цэрлэгийг шинэчлэн бүртгэх ажлыг 1998 оны 12 дугаар рд багтаан зохион байгуулах;

2/"Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт уулах тухай" хуулийн дагуу их сургууль, коллежийг 98-1999 оны хичээлийн жилд багтаан аккредитацид мруулж, боловсролын зэрэг олгох сургалтын түвшин гтоох;

3/дээд боловсролын диплом, бакалавр, докторын рэг олгох сургалтын агуулгыг нарийвчлан тогтоон, рэг олгох тухай үлгэрчилсэн журмыг 1998 онд багтаан ргаж мөрдүүлэх, 1999-2000 оны хичээлийн жилээс эх-н магистр, докторын зэрэг олгох сургалтанд шилжих;

4/бүх шатны сургууль, цэцэрлэгийн удирдах зөвлөл йгуулах ажлыг 1999 онд багтаан зохион байгуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо .Хулан/-ид даалгасугай.

ДАРГА | | Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
## ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар<br>сарын 23-ны өдөр | Дугаар 81 | Улаанбаатар<br>хот |

**Хууль баталсантай холбогдуулан авах**
**зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дайчилгааны тухай хууль батлагдсантай холбогду
лан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засги
газар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай:

1/Засгийн газраас дайчилгаатай холбогдуулан өм
баталсан тогтоол, шийдвэрийг 1998 онд багтаан Дайчи
гааны тухай хууль тогтоомжтой нийцүүлэх;

2/Дайчилгааны тухай хуулиар Засгийн газраас ба
лахаар заасан дүрэм, журмыг 1998 онд багтаан гаргах

3/дайчилгааны сургалт, бэлтгэлийн арга хэмжэ
шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг 1998 оны батл
хамгаалах арга хэмжээний төсөвт багтаан зохицуула
хийх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажилла
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хор
/Д.Энхбаатар/-нд даалгасугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
## ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар<br>сарын 24-ний өдөр | Дугаар 82 | Улаанбаатар<br>хот |

**Санал хураах комисс**
**байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газрыг огцруулах эсэх асуудлаар са
хураалтыг зохион байгуулж, дүнг гаргах үүрэг бү
комиссыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бямбадорж, Т.Ган
Ё.Гэрэлчулуун, С.Ламбаа нарын бүрэлдэхүүнтэй байгуу
сугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

998 оны 7 дугаар арын 24-ний өдөр | Дугаар 83 | Улаанбаатар хот

### Засгийн газрыг огцруулах тухай

лсын Их Хурлын нэр бүхий 26 гишүүнээс лбэгдоржийн тэргүүлсэн Засгийн газрыг огцруулах ай тавьсан саналыг хэлэлцээд нууцаар санал эхад, чуулганы хуралдаанд оролцсон Улсын Их лын гишүүдийн 42 нь буюу 56 хувь нь Засгийн газрыг руулах саналыг дэмжсэн тул Монгол Улсын Үндсэн ийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, дочин вдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Их лын хуралдааны дэгийн хуулийн 17 дугаар зүйлд ныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

.Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь ууулсугай.

.Шинэ Ерөнхий сайдыг томилогдох хүртэл үүрэгт ра гүйцэтгэж байхыг Ерөнхий сайд /Ц.Элбэгдорж/-д, эр Засгийн газрын гишүүн-сайд томилогдтол үүрэгт ра гүйцэтгэж байхыг Засгийн газрын гишүүдэд агасугай.

.Энэ тогтоолыг 1998 оны 7 дугаар сарын 24-ний эс эхлэн дагаж мөрдөнө.

АРГА | Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

998 оны 7 дугаар арын 24-ний өдөр | Дугаар 84 | Улаанбаатар хот

### Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

онгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ский бүдүүвчийн тухай" Улсын Их Хурлын 1996 оны 8 ар сарын 30-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор лсан хавсралтад Сангийн сайдын эрхлэх асуудлын

хурээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентла Гадаадын хөрөнгө оруулалтын газрыг Гадаад харилцаа сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлж "Гадаад хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг" болго өөрчилсүгэй.

**ДАРГА** Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

**1998 оны 7 дугаар сарын 30-ны өдөр** **Дугаар 85** Улаанбаатар хот

**Засгийн газрын бонд гаргахыг зөвшөөрөх тухай**

Үнэт цаасны тухай Монгол Улсын хуулийн 7 дуга зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Хурлаас ТОГТООХ нь:

Эдийн засагт байгаа сул чөлөөтэй мөнгөн хөрөнги эргэлтэнд оруулах замаар мөнгөний нийлүүлэлти зохицуулах, инфляцийг тогтвортой байлгахад дэмжл үзүүлэх, төсвийн нэмэлт эх үүсвэр бүрдүүлэх, зарла санхүүжилтийг уян хатан, шуурхай удирдлагаар ханг зорилгоор 20 /хорь/ хүртэл тэрбум төгрөгийн бо гаргахыг Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т зөвшөөрсүгэ

**ДАРГА** Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

**1998 оны 7 дугаар сарын 30-ны өдөр** **Дугаар 86** Улаанбаатар хот

**Байнгын хороодын гишүүнээр батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дуга зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 д

сгийн 5 дахь заалт, өөрсдийнх нь гаргасан хүсэлтийг дэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:
Улсын Их Хурлын гишүүн Ц.Өөлдийг Төрийн байгуу-лтын байнгын хороо болон Эдийн засгийн байнгын роо, Улсын Их Хурлын гишүүн Д.Цэвээнжавыг Төрийн йгуулалтын байнгын хороо болон Нийгмийн бодлогын йнгын хорооны гишүүнээр тус тус батлсугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1998 оны 8 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 89 | Улаанбаатар хот

**Байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, гишүүнээр батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр йлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний х зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх сгийн 5 дахь заалт, өөрсдийнх нь гаргасан хүсэлтийг дэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:
Улсын Их Хурлын гишүүн Ц.Ганхуягийг Төсвийн йнгын хорооны гишүүнээр, Улсын Их Хурлын гишүүн Дамбаа, Д.Цогт-Очир нарыг Эдийн засгийн байнгын рооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Төрийн байгууллалтын йнгын хорооны гишүүнээр, Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийг Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн йнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Төрийн йгуулалтын байнгын хорооны гишүүнээр тус тус талсугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 94 | Улаанбаатар хот |

**П.Тэргүүнд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай**

Мал аж ахуйн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажилла гучаад жил улсын бэлтгэлийн мал тууварлан, жинг нэмэгдүүлэн ол тонн мах даалгавраас давуулан тушааж, хүн амын хүнс хангамжийг нэмэгдүүлэхэд оруулж байгаа жинтэй хувь нэмрийг үнэлж Говь-Алтай аймгийн Шарга сумын туувар малчин Палам Тэргүүнд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртэ Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 95 | Улаанбаатa хот |

**Ц.Цэвээн-Очирт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай**

Авто замын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, х олноо чадварлаг удирдан зохион байгуулан, өндөр уулын бүс томоохон голуудад олон төмөр бетон болон модон гүүр, сайжруул хайрган замыг чанартай барьж, зам гүүр, замын сүлжээг хөгжү үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Архангай аймг "Авто-зам Архангай" ХК-ийн гүйцэтгэх захирал Цэрэндорж Цэвээн-Очирт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүргээсүгэй

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 96 | Улаанбаатар хот |

**П.Балдандоржид Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Дүрслэх урлагийн салбарт олон жил үр бүтээлтэй хөдөлмөрлөж, л чимэглэлийн болон хөрөг зургуудыг мэргэжлийн өндөр ур вар гаргаж туурвих, ардын урлагийн өвийг залуу үед уламжлуулах ісэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсын их гуулийн ардын урлаг судлалын тэнхмийн багш Пунцагнамжилын цандоржид Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол тээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 97 | Улаанбаатар хот |

**Д.Мөнхөд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Дүрслэх урлагийн салбарт олон жил үр бүтээлтэй хөдөлмөрлөж, галийн болон хөрөг, сэдэвт уран зургуудыг мэргэжлийн өндөр ур вар гарган туурвиж, монголын дүрслэх урлагийг хөгжүүлэхэд улж байгаа хувь нэмрийг нь үнэлж бие даасан уран бүтээлч ібэрэлийн Мөнхөд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол гээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 98 | Улаанбаатар хот

**А.Лхамсүрэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай**

Ерөнхий боловсролын сургуульд олон жил үр бүтээлтэй ажиллаж богино хугацаанд үр дүнд хүрэх дэвшилтэт, эрчимт арга барилы сургалтад санаачлан нэвтрүүлж, хэд хэдэн сурах бичиг зохиолцов өсвөр үеийг сурган хүмүүжүүлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрий нь үнэлж Нийслэлийн 93 дугаар сургуулийн бага ангийн баг Анандын Лхамсүрэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 99 | Улаанбаатар хот

**Ж.Наранд Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээх тухай**

Монголын иргэний агаарын тээврийн байгууллагад олон жил бүтээлтэй хөдөлмөрлөн манай оронд ашиглагдаж байгаа иргэн тээврийн нисэх онгоцуудыг чадамгай эзэмшиж, нислэгийн аюулгү байдлыг найдвартай хангаж ажиллаж байгааг нь үнэлж "МИАТ" компанийн АН-24 онгоцны нисгэх багийн дарга Жамбалдоржийн Наранд Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 100 | Улаанбаатар хот

**Ж.Намнанбаярт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай**

Урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй хөдөлмөрлөж, хийн болон үндэсний сонгодог бүжгийн жүжгийн дүрүүдийг гэжлийн өндөр түвшинд чадварлаг бүтээж, эх орондоо сонгодог гийн жүжгийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж Сонгодог урлагийн академик театрын бүжгийн ээлэгийн захирал Жамъянжавын Намнанбаярт Монгол Улсын ьяат жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 101 | Улаанбаатар хот

**Д.Жаргалсайханд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай**

Үзэгчдийн сэтгэлд хоногшсон олон арван дуу зохион дуулж, дан рн жүжгийн хөгжмийн зохиол бичин, рок, поп урлагийн залуу йг сургаж бэлтгэх, эстрадын урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа нэмрийг нь үнэлж "Чингис хаан" хамтлагийн ахлагч, дуучин ээвэгийн Жаргалсайханд Монгол Улсын гавьяат жүжигчин цол ээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 102 | Улаанбаатар хот

**Г.Энхболдод Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, ол арван жүжиг, концерт найруулан тавьж, урлагийн залуу үеийхни сургах, ардын урлагийг хөгжүүлэх, гадаад орнуудад сурталчла оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хэнтий аймгийн ардын д бүжгийн "Хан Хэнтий" чуулгын уран сайхны удирдагч Гаалангі Энхболдод Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** — **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 103 | Улаанбаата хот

**Т.Түвшинд Монгол Улсын гавьяа багш цол хүртээх тухай**

Хүүхдийн байгууллагад санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, олноо чадварлаг зохион байгуулан, байгууллагаа аж ахуй санхүүг хувьд бэхжүүлж, хүүхдүүдийн амралт чөлөөт цагийг үр аши өнгөрүүлэх, авьяас билгээ хөгжүүлэх, монголын хүүхдүүдийг га орны үе тэнгийнхэнтэйгээ танилцаж нөхөрлөх нөхцөл боломжоо хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Олон у хүүхдийн "Найрамдал" төвийн ерөнхий захирал Түлшигийн Түвш Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** — **Н.БАГАБАНДИ**

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 104 | Улаанбаатар хот

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Үйлдвэрлэл, үйлчилгээ, соёл боловсрол, эрүүл мэндийн салбар, уль хяналт, төр, захиргаа, олон нийтийн байгууллагад олон жил үр гээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар агнасугай.

## ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР

| | |
|---|---|
| Ланзадын Балдорж | -Архангай аймгийн Хөгжимт жүжгийн театрын гоцлол дуучин |
| Гүрэнжавын Доржламба | -Төв аймгийн Ус суваг, орон сууцны "Чандмань" ХК-ийн захирал |
| онгийн Доржханд | -Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэлгийн ерөнхий эмч |
| лхагийн Нармандах | -Улаанбаатар хотын Боловсролын газрын мэргэжилтэн |
| Камбын Эрхэмбаяр | -Нийслэлийн Баянгол дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн захирал |
| алдангийн Янжмаа | -Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт |

## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР

| | |
|---|---|
| ржаагийн Уртнасан | -Увс аймгийн Цагдаагийн хэлтсийн эдийн засгийн ахлах төлөөлөгч, хошууч |

## "АЛТАН ГАДАС" ОДОНГООР

| | |
|---|---|
| аасандоржийн Алтан | -"АПУ" ХК-ийн архи, ундааны үйлдвэрийн дарга |
| анжийн Банзрагч | -Төрийн хянан шалгах хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга |

| | |
|---|---|
| 3.Төмөр-Очирын Батжаргал | -Худалдааны техникийн "Тулга" ХК-ийн цехийн дарга |
| 4.Цэнджавын Батсүх | -Улаанбаатар хотын Түргэн тусламжийн төвийн ээлжийн ахлагч, их эмч |
| 5.Очирбатын Гунаажав | -Хөвсгөл аймгийн Тариалан сумын Засаг дарга |
| 6.Нансалжавын Гэрэлсүрэн | -Монголын эмэгтэйчүүдийн холбооны Ерөнхийлөгч |
| 7.Сосорын Даваажав | -Дундговь аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн хүүхдийн зөвлөх их эмч |
| 8.Нямын Мөнхнар | -Сүхбаатар аймгийн Хянан шалгах хорооны дарга |
| 9.Мөнх-Очирын Нацаг-Ю[illegible] | -Архангай аймгийн Ихтамир сумын багийн бага сургуулийн эрхлэгч |
| 10. Намсрайжавын Нам | -Дархан-Уул аймгийн "Монгол алт" ХК-ийн алтны уурхайн ахлах геологич |
| 11.Шаравын Сүхбаатар | -Худалдааны техникийн "Тулга" ХК-ийн механикч |
| 12.Бадамын Хишигтогтох | -"АПУ" ХК-ийн архи, ундааны үйлдвэрийн технологич |
| 13.Чойвоогийн Үржмаа | -МАХН-ын дэргэдэх "Эмэгтэйчүүд хөгжил" хөдөлгөөний нарийн бичгийн дарга |
| 14.Чүлтэмийн Цэрэнбүтэд | -Баянхонгор аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга |
| 15.Жамцын Чойжанцан | -Улсын Ерөнхий прокурорын орлогч |
| 16.Рэнчингийн Дуламсүрэн | -Өвөрхангай аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн ерөнхий эмч |
| 17.Шаравын Загд-Очир | -Орхон аймгийн Жаргалант сумын "Талын нуур" ХК-ийн тракторч-комбайнч |
| 18.Сэрээтэрийн Намсрайжав | -Архангай аймгийн Өндөр-Улаан сумын дунд сургуулийн багш |

## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

| | |
|---|---|
| 1.Мандирын Амгалан | -Хөвсгөл аймгийн Цагдаагийн хэлтсийн эдийн засгийн хэлтсийн ахлах төлөөлөгч, хошууч |

| | |
|---|---|
| Балчиндоржийн Түмэнбаяр | -Цагдаагийн ерөнхий газрын эдийн засгийн хэлтсийн ахлах төлөөлөгч, хошууч |

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

| | |
|---|---|
| Галдангийн Болдбаатар | -Дорнод аймгийн Байгалийн гамшигтай тэмцэх салбарын шүхэрчин гал сөнөөгч |
| Аюушийн Гонгор | -Баян-Өлгий аймгийн Өлгий сумын дунд сургуулийн багш |
| Шаравын Мөнхбат | -Сэлэнгэ аймгийн Зам засвар, арчлалтын компанийн захирал |
| Донлогийн Чулуунбүргэд | -Олон улсын хүүхдийн "Найрамдал" төвийн шахилгааны инженер |
| Сүнрэвийн Энхбаатар | -Хэнтий аймгийн Бэрхийн уулын үйлдвэрийн нэвтрэгч, тэсэлгээчин |

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 8-ны өдөр — Дугаар 105 — Улаанбаатар хот

Д.Базарсадад хошууч генерал цол хүртээх тухай

Хилийн цэргийн удирдах газрын дарга, Хилийн цэргийн мандлагч Дашбалбарын Базарсадад хошууч генерал цол ртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 14-ний өдөр | Дугаар 107 | Улаанбаат хот

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний тухай**

"Шүүхийн тухай хууль"-ийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Цэрэнхүүгийн Шаравдоржийг Монгол Улсын Шүүхийн ерөн зөвлөлийн гишүүнээр томилж, Чимиддоржийн Амарболдыг Шүүх ерөнхий зөвлөлийн гишүүний үүргээс чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 108 | Улаанбаата хот

**Ц.Бумцэндэд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай**

Төмөр замын тээвэрт илчит тэрэгний машинчаар олон жил бүтээлтэй ажиллаж, галт тэргээр зорчигч тээвэрлэх хариуцлаг үүргийг мэргэжлийн өндөр ур чадвар гарган гүйцэтгэж, үйлд лэлийн төлөвлөгөөт даалгаврыг тогтмол давуулан биелүүлж, тө замын тээврийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад оруулж ба жинтэй хувь нэмрийг нь үнэлж Улаанбаатар төмөр замын зүтгүү депогийн машинч Цагааны Бумцэндэд Монгол Улсын хөдөлмө баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмд шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 109 | Улаанбаатар хот

**Р.Рашт Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай**

Төмөр замын тээвэрт санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, цаэрлэл, хамт олныг чадварлаг удирдан төмөр замын тээврийг жүүлэн материаллаг баазыг бэхжүүлэх, тогтвортой үйл ажиллагааг гах, үр ашгийг нэмэгдүүлэх, боловсон хүчин бэлтгэх, төмөр чдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд оруулж байгаа хувь арийг нь үнэлж Улаанбаатар төмөр замын Хэрэг эрхлэх газрын га Раднаабазарын Рашт Монгол Улсын гавьяат тээвэрчин цол тээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 110 | Улаанбаатар хот

**Д.Энхтуяад Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Төмөр замын тээвэрт олон жил үр бүтээлтэй ажиллаж, хариуцсан оны тоног төхөөрөмж, эд хогшлыг байнга бүрэн бүтэн, цэвэр мжтэй байлгаж, зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг дүүлэн, үйлчилгээний соёлч байдлыг нэвтрүүлэхэд оруулж байгаа ь нэмрийг нь үнэлж Улаанбаатар төмөр замын суудлын вагон огийн вагоны үйлчлэгч Даваажавын Энхтуяад Монгол Улсын чилгээний гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 111 | Улаанбаатар хот |

**Улаанбаатар төмөр замын зарим ажилтан, ажилчдыг одон, медалиар шагнах тухай**

Улаанбаатар төмөр замд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан ажилтан, ажилчдыг Монгол Улсад төмөр замын тээвэр байгуулагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан одон, медалиар шагнасугай.

## ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

| | |
|---|---|
| 1.Наваанжамцын Батмөнх | -УБТЗ-ын Хэрэг эрхлэх газрын орлогч дарга |
| 2.Жигжидийн Нямаа | -УБТЗ-ын Хэрэг эрхлэх газрын ерөнхий инженер |
| 3.Ядамсүрэнгийн Шархүү | -УБ зүтгүүрийн депогийн засварчин |

## "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

| | |
|---|---|
| 1.Цэндийн Алтанцэцэг | -УБТЗ-ын "Ган зам" цэцэрлэгийн эрхлэгч |
| 2.Очирын Бадамсэд | -УБТЗ-ын Хэрэг эррхлэх газрын хэлтсийн дарга |
| 3.Цэдэнгийн Базаррагчаа | -УБТЗ-ын төв эмнэлгийн мэс заслын их эмч |
| 4.Дашзэгвийн Балжинням | -УБТЗ-ын зүтгүүрийн депогийн илчит тэрэгний машинч |
| 5.Батжавын Батмөнх | -Эрчим хүч, ус хангамжийн I ангийн мастер |
| 6.Ендонгийн Батсайхан | -УБТЗ-ын Хэрэг эрхлэх газрын орлогч дарга |
| 7.Дэмбэрэлийн Будхүү | -УБТЗ-ын коллежийн захирал |
| 8.Галдангийн Вандандагва | -УБТЗ-ын Хэрэг эрхлэх газрын Замын албаны дарга |
| 9.Юндэнгийн Гомбодорж | -Замын II ангийн орлогч дарга |

| | |
|---|---|
| Буянцогтын Гончиг | -Дархан өртөөний жижүүр |
| Лүндэнгийн Дамдин | -Төмөр замчдын ҮЭ-ийн холбооны дарга |
| Гүвдэннямын Дашдэмбэрэл | -УБТЗ-ын Хэрэг эрхлэх газрын Ачаа тээврийн албаны хэлтсийн дарга |
| Юндэнгийн Идэрчулуун | -УБТЗ-ын зүтгүүрийн депогийн дарга |
| Шоовомын Мэнига | -Барилга, орон сууцны III ангийн хэсгийн дарга |
| Жигжийн Найдансүрэн | -Чойрын замын III ангийн дарга |
| Доржийн Пүрэвжав | -Зам засварын машинт станцын дарга |
| Крисбайн Рашат | -Галт тэрэгний хөдөлгөөний улсын байцаагч |
| Энирын Сүрэн | -УБТЗ-ын суудлын вагон депогийн дарга |
| Дуламсүрэнгийн Цогоо | -Мөн депогийн засварчин |
| Батцэнгэлийн Цолмон | -УБТЗ-ын төв эмнэлгийн эмэгтэй-чүүдийн их эмч |
| Гунгаажавын Цэвэлмаа | -УБТЗ-ын 5 дугаар гуанзны ахлах тогооч |
| Содовын Цэгмэд | -Барилга үйлдвэрлэлийн нэгдлийн барилгын бригадын дарга |
| Мөнхөөгийн Цэрэн-Очир | -УБТЗ-ын автобаазын жолооч |
| Алтангэрэлийн Чулуунбат | -УБТЗ-ын Хэрэг эрхлэх газрын инженер-эдийн засагч |
| Баалийн Шаравжамц | -Худалдаа хангамжийн албаны дарга |
| Мөнхийн Шаравсамбуу | -Барилга, орон сууцны II ангийн дарга |
| Нямын Ширмэндугар | -Улаанбаатар өртөөний сэлгээний зохицуулагч |

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

| | |
|---|---|
| Гэрсүрэнгийн Амар | -Зүүнхараа дахь вагон засварын депогийн дарга |
| Содовын Аюур | Сүхбаатар зүтгүүрийн депогийн машинч |

| | |
|---|---|
| 3.Жавын Баатар | -Цагаанхэр зэрлэгийн холбооны механикч |
| 4.Маамын Батжаргал | -Сайншандын гал унтраах ангийн салааны дарга |
| 5.Түмэн-Өлзийн Батцэнгэл | -Дохиолол холбооны I ангийн дарг |
| 6.Сүхийн Баяраа | -Барилга, орон сууцны I ангийн засварчин |
| 7.Зургаадайн Буян | -Замын-Үүд өртөөний вагон үзэгч |
| 8.Лхамсүрэнгийн Бямбаа | -Ачаа тээврийн албаны инженер |
| 9.Жандагийн Бямбасүрэн | -"Найрамдал" цэцэрлэгийн эрхлэгч |
| 10.Оргодлын Ганбаатар | -Замын IY ангийн замчин |
| 11.Чимэдийн Ганбат | -Улаанбаатар өртөөний галт тэрэгний найруулагч |
| 12.Юубилээгийн Ганболд | -Сайншандын зүтгүүрийн депогийн машинч |
| 13.Балданжамцын Гончиг | -Сайншандын цахилгаан станцын дарга |
| 14.Жүгдэрнамжилын Гэрэлтбямба | -Галт тэрэгний хөдөлгөөний зохицуулагч |
| 15.Аюушийн Дамдинсүрэн | -УБТЗ-ын Төв засварын газрын гагнуурчин |
| 16.Самбуугийн Дашбалжир | -Замын III ангийн мастер |
| 17.Жадамбын Дашдорж | -Замын I ангийн бригадын дарга |
| 18.Бэгзийн Дашнам | -Улаанбаатар суудлын вагон депогийн бригадын дарга |
| 19.Жамбаагийн Жанчив | -Зорчигч тээврийн албаны орлогч дарга |
| 20.Гүнгрэнзийн Жаргалсайхан | -Галын галт тэрэгний моторчин |
| 21.Халиуны Лхагвасүрэн | -УБТЗ-ын зүтгүүрийн албаны дар |
| 22.Галсантогтохын Мягмар | -Замын III ангийн ерөнхий нягтл бодогч |
| 23.Ванчигдоржийн Отгондэмбэрэл | -УБТЗ-ын ХЭГ-ын удирдлага төлөвлөлтийн албаны дарга |

| | |
|---|---|
| Гүнчингийн Очирбат | -Барилга, орон сууцны II ангийн ажилчин |
| Цагааны Оюун | -УБТЗ-ын Хэвлэх үйлдвэрийн мастер |
| Жумдааны Пүрэв | -Дорнодын төмөр замын хөдөлгөөн хариуцсан улсын байцаагч |
| Жамъянжавын Сэлэнгэ | -УБТЗ-ын төв эмнэлгийн их эмч |
| Зулын Улаанхүү | -Улаанбаатар буудлын пүүлэгч, тээш түгээгч |
| Дагвын Хатанбаатар | -Чойр өртөөний дарга |
| Гүншингийн Цэвэл | -УБТЗ-ын мод боловсруулах үйлдвэрийн цехийн мастер |
| Чойндонгийн Цэвээн | -Чойр өртөөний худалдааны конторын худалдагч |
| Цэдэндамбын Дэлэндулам | -Сүхбаатар өртөөний ачаа тээврийн ахлах агент |
| Борголөгийн Цэрэндаш | -Дорнодын төмөр замын ахлах замчин |
| Ядамын Цэрэндаш | -Замын-Үүд өртөөний ачаа, вагон хүлээлцэгч |
| Батаагийн Чанцалдулам | -УБТЗ-ын Соёлын ордны хөгжимчин |
| Дэлэвийн Чулуунбаатар | -Зам засварын машинт станцын краны машинч |
| Гомбын Чулуунбат | -Зүүнхараа дахь Нэгдсэн эмнэлгийн их эмч |
| Гүндсамбуугийн Шийтэрхүү | -Ачих буулгах ангийн ягуулахын эрхлэгч |

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 112 | Улаанбаатар хот |

**Б.Ф.Сусликовыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай**

Монгол-Оросын хамтарсан "Эрдэнэт" үйлдвэрийн үйлдвэрлэлий нөөц бололцоог ашиглах, төслийн хүчин чадлыг эзэмших, шин дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, монгол мэргэжилтнүүдий сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ту үйлдвэрийн баяжуулах фабрикийн дарга Борис Филиппови Сусликовыг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 113 | Улаанбаатар хот |

**Г.Ч.Ширшинийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай**

Монгол Улс, ОХУ-ын ард түмний найрсаг харилцааг хөгжүүлэ хил орчмын хамтын ажиллагааг өргөтгөхөд оруулж байгаа ху нэмрийг нь үнэлж ОХУ-ын Бүгд Найрамдах Тува Улсын ирг Григорий Чоодуевич Ширшинийг "Алтан гадас" одонго шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 114 | Улаанбаатар хот |

**Ц.Эрдэнэбаатарыг "Шударга журам" медалиар шагнах тухай**

Гал түймрийн аюулаас улс, иргэдийн их хэмжээний өмч өрөнгө хамгаалсан болон хүнд өвчтөн, эх үрсийн амийг аврахын лд тавь гаруй удаа цусаа өгсөн Баянхонгор аймгийн Гал түймэртэй мцэх албаны гал сөнөөгч, донор Цэенгийн Эрдэнэбаатарыг Шударга журам" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 115 | Улаанбаатар хот |

**Н.Өлзийжаргалыг "Шударга журам" медалиар шагнах тухай**

Хүчтэй салхи, шороон шуурганы үед авхаалж самбаа, зориг эчээр гарган хонин сүргээ хорогдолгүй авран хамгаалсан өрхангай аймгийн Бога сумын иргэн, 9 настай охин Нинагийн зийжаргалыг "Шударга журам" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 116 | Улаанбаатар хот |

**Ц.Пүрэвдоржийг "Шударга журам" медалиар шагнах тухай**

Галын аюулаас эр зориг, авхаалж самбаа гарган хүүхдүүдийн амь аварч иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Увс аймгийн Улаангом сумын ахуй үйлчилгээний "Уянга" хоршооны мужаан Цоохүүгийн Пүрэвдоржийг "Шударга журам" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 117 | Улаанбаатар хот |

**М.Онгар, Б.Тойлыбай нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай**

Хээрийн түймрийн аюулаас эр зориг, авхаалж самбаа гарган хүүхдийн амь аварч иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Ховд аймгийн Ховд сумын иргэн, ногоочин Мархашханы Онгар, малчин Батанбайн Тойлыбай нарыг "Шударга журам" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 22-ны өдөр — Дугаар 118 — Улаанбаатар хот

**Ч.Мөнхцэцэгт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай**

Үндэсний сур, тэшүүрийн спортоор өндөр амжилт гаргаж, улсын баяр наадамд үндэсний сур харвалтаар тав түрүүлж дээр дуурсах дархан мэргэн цол хүртэж, тэшүүр, сурын улсын аваргаар олон удаа шалгарч, тэшүүрийн улсын дээд амжилтыг хэд дахин шинэчлэн тогтоож, эдгээр спортын төрлийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Цагдаагийн ерөнхий газрын Эргүүл хамгаалалтын 801 дүгээр хорооны ажилтан Чойжилсүрэнгийн Мөнхцэцэгт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** — **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 22-ны өдөр — Дугаар 119 — Улаанбаатар хот

**П.Ганбатад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай**

Дэлхийн сонгодог болон үндэсний дуурийн гол дүрүүдийг чадварлаг бүтээж, дуурийн дуучдын олон улсын хэмжээний уралдаанд удаа дараа амжилттай оролцож шагналт байр эзлэн, монголын дуурийн урлагийн алдар нэрийг дэлхий дахинд түгээж, дуурийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сонгодог урлагийн академик театрын гоцлол дуучин Пүрэвжавын Ганбатад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** — **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 120 | Улаанбаатар хот |

**Цагдаагийн байгууллагын зарим ажилтныг одон, медалиар шагнах тухай**

Цагдаагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

### "АЛТАН ГАДАС" ОДОНГООР

Очирын Олзэрэл -Цагдаагийн ерөнхий газрын харьяа Биеийн тамир, спортын "Хүч" хорооны тамирчин

### ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1.Баасжийн Алтангэрэл -Замын цагдаагийн газрын зохицуулагч, ахлах ахлагч

2.Шаравын Ганболд -Эрүүгийн цагдаагийн газрын эдийн засгийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ахлах ажилтан, дэд хурандаа

3.Гомбосүрэнгийн Смирнов -Банк хамгаалах 809 дүгээр ангийн цагдаа, ахлах ахлагч

### ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

1.Цэгмидийн Арвинбуудай -Мөрдөн байцаах газрын 5 дугаар хэлтсийн чиглэлийн ахлах ажилтан, хошууч

2.Ламжавын Базаррагчаа -Хөвсгөл аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн ахлах байцаагч, хошууч

3.Пүрэвийн Батбаяр -Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсийн гал унтраах 10 дугаар ангийн гал сөнөөгч, ахлах ахлагч

4.Ранжавын Лхагва -Цагдаагийн ерөнхий газрын автобаазын засварчин, ахлах ахлагч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 121 | Улаанбаатар хот |

**"Эрэл" ХХК-ийн зарим ажилтан, ажилчдыг одон, медалиар шагнах тухай**

Барилгын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа Үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн доор дурдсан ажилтан, ажилчдыг одон, медалиар шагнасугай.

### "АЛТАН ГАДАС" ОДОНГООР

| | |
|---|---|
| Цэрэнгийн Жаргал | -"Эрэл" ХХК-ийн "Эрэлстрой" компанийн гүйцэтгэх захирал |
| Наваансодовын Хүрэлбаатар | -"Эрэлстрой" компанийн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал |
| Лхагвын Цэвээн | -"Эрэлстрой" компанийн ахлах инженер |

### ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

| | |
|---|---|
| Дашдаваагийн Лхасүрэн | -"Эрэл" ХХК-ийн Барилгын хийц эдлэлийн үйлдвэрийн сантехникийн механикч |
| Чойнорын Цогбадрах | -Мөн үйлдвэрийн засварчин |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 122 | Улаанбаатар хот

**Д.Батбаярт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай**

Мэргэжлийн сумо бөхийн төрлөөр богино хугацаанд дэ
зиндаанд дэвшин барилдаж, уран барилдааны шагнал удаа дар
хүртэн, спортын өндөр амжилт тогтвортой гаргаж, эх орныхоо н
хүндийг дэлхий дахинд алдаршуулах үйлсэд оруулж байгаа ху
нэмрийг нь үнэлж мэргэжлийн сумо бөхийн тамирчин Даваагі
Батбаярт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 123 | Улаанбаатар хот

**Н.Цэвэгням, Б.Энхбат нарыг одонгоор шагнах тухай**

Сумо бөхийн спортоор өндөр амжилт гаргаж эх орныхоо н
хүндийг алдаршуулах үйл хэрэгт оруулж байгаа хувь нэмрийг үнэ
мэргэжлийн сумо бөхийн тамирчин Нямжавын Цэвэгнямыг Хөд
морийн гавьяаны улаан тугийн одонгоор, Батмөнхийн Энхбат
"Алтан гадас" одонгоор тус тус шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 24-ний өдөр | Дугаар 125 | Улаанбаатар хот

**Шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Монгол Улсын Шүүхийн тухай хууль"-ийн 51 дүгээр зүйлийн 1 эх хэсгийн 1, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн омбосүрэнгийн Ганзоригийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан ушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 7 дугаар сарын 24-ний өдөр | Дугаар 126 | Улаанбаатар хот

**Шүүгчийг томилох тухай**

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн андагийн Нямжавыг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд эмилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 24-ний өдөр | Дугаар 127 | Улаанбаатар хот |

**Шүүгчдийг албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Пүрэвийн Загдааг Завхан аймгийн ерөнхий шүүгчийн, Лувсандоржийн Бямбааг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн, Сандагийн Нямжавыг Булган аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн, Чойжамцын Энхболдыг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Гомбожавын Туулхүү, Цэдэн-Ишийн Туяа нарыг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Дэчингомбын Цэрэндолгор, Нямдоржийн Алъяа нарыг Хэнтий аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн, Дэндэвийн Батсуурь, Батхишигийн Баттулга нарыг Увс аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ — Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 7 дугаар сарын 24-ний өдөр | Дугаар 128 | Улаанбаатар хот |

**Шүүгчийг томилох тухай**

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Шагдаргомбын Төмөрбаатарыг Дундговь аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн, Лувсандоржийн Бямбааг Нийслэлийн шүүхийн шүүгчийн, Пүрэвийн Лагчааг Говь-Алтай аймгийн шүүхийн шүүгчийн, Түмэнбаярын Энхжаргалыг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Цэвээндоржийн Алтанцэцэгийг Говь-Сүмбэр аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Цэрэндоржийн Баасанжавыг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Намсрайн Балжмааг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Дэчингомбын Цэрэндолгор, Нямдоржийн Алъяа нарыг Хэнтий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн,

...эвийн Батсуурь, Батхишигийн Баттулга нарыг Увс аймаг дахь ... дундын шүүхийн шүүгчийн, Замбын Минжирмаа Нийслэлийн ...гэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн, Балжиннямын Оюуныг ...баатар дүүргийн шүүхийн шүүгчийн, Лувсаншаравын Сарангуа, ...цэрэнгийн Давaсүрэн нарыг Сонгинохайрхан дүүргийн шүүхийн ...гчийн албан тушаалд тус тус томилсугай.

...ОНГОЛ УЛСЫН
...РӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

...998 оны 7 дугаар ...арын 29-ний өдөр Дугаар 133 Улаанбаатар хот

Шүүгчийг томилох тухай

...Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Цэдэн-Ишийн ... Дархан-Уул аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалд ...лсугай.

...ОНГОЛ УЛСЫН
...РӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 7 дугаар сарын 1-ний өдөр    Дугаар 107    Улаанбаатар хот

**Төсөл гэрээгээр гүйцэтгүүлэх тух**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
Засгийн газрын тухай Монгол Улсын хуулийн дугээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэсл Нидерландын Вант Улсын Засгийн газрын буцалтгүй ту ламжаар улсын тусгай хамгаалалттай газар нута Хустайн байгалийн нөөц газарт хэрэгжүүлж байга хамгаалалт, менежмент, судалгааны болон та нутагшуулах төслийг Монголын байгаль орчныг хамгаал холбоонд гэрээний үндсэн дээр хариуцуул гүйцэтгүүлэхийг Байгаль орчны сайд С.Баярцогт зөвшөөрсүгэй.

**Монгол Улсын Ерөнхий сайд** Ц.ЭЛБЭГДОРЖ

**Байгаль орчны сайд** С.БАЯРЦОГТ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 7 дугаар сарын 1-ний өдөр    Дугаар 109    Улаанбаатар хот

**Гадаад сурталчилгааг уялдуулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
1.Улс орноо гадаадад таниулж мэдүүлэх, сурталч ажлыг нэгдсэн бодлоготой явуулахыг Гадаад харилцаа яаманд даалгасугай.
2.Гадаад харилцааны сайд Р.Амаржаргалд дор дурдс арга хэмжээг авч хэрэгжүүлж байхыг даалгасугай:
а/гадаад сурталчилгаа явуулах төслүүдийг Гада харилцааны яам хүлээн авч, мэргэжлийн байгууллага оролцоотойгоор сонгон шалгаруулж, шалгарсан төсл дийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийд гаргуулж байх;

б/Засгийн газрын шийдвэрийг үндэслэн төслийг эрэгжүүлэгч эсвэл захиалагчтай тухай бүр гэрээ айгуулж байх;

в/гадаад сурталчилгаанд зориулан гаргуулсан эренгийн зарцуулалтын талаархи санхүүгийн тайланг эхих журмын дагуу Сангийн яаманд хүргүүлж байх;

г/шалгарсан төслийн хэрэгжилт, үр дүнг нэгтгэн ргаж, Засгийн газрын хуралдаанд тухайн жилийн IY ирэлд багтаан оруулах.

3.Шалгарсан төслийн зардлыг тухайн жилийн улсын эсвт гадаад сурталчилгаанд зориулан тусгасан эренгээс гаргаж байхыг Сангийн сайд Б.Батбаярт амээрсугэй.

Монгол Улсын Ерөнхий сайд Ц.ЭЛБЭГДОРЖ

Гадаад харилцааны сайд Р.АМАРЖАРГАЛ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Дугаар 110 Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Бүртгэл тооцооны ажлыг сайжруулан салбарын эдийн сгийн үр ашгийг дээшлүүлэх, мал аж ахуй, газар риалан, боловсрол, шинжлэх ухааныг хөгжүүлэх, хүн ын эрүүл мэндийг сахин хамгаалах үйлст үнэтэй хувь эмэр оруулан, идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж йгааг нь тэмдэглэж дор дурдсан хүмүүсийг Монгол сын Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнасугай:

-"НИК" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч Оросоогийн НДБАЯР;

-Өмнөговь аймгийн Хүрмэн сумын малчин, ардын аж үйтан Гажидын БУД;

-Дорнод аймгийн Чойбалсан сумын "Ургац Импекс" К-ийн ерөнхий захирал Гомбосүрэнгийн АЛИМАА;

-Техникийн их сургуулийн ректор Дэндэвийн БАДАРЧ;

-Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны сүрьеэгийн ерөнхий мэргэжилтэн, Сүрьеэгийн үндэсний төвийн захирал Гомбогарамын ЦОГТ.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

**Сангийн сайд** **Б.БАТБАЯР**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

1998 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 114 Улаанбаатар хот

**Банкны талаар авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1998 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 10 тоот зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Ажлын хэсгийн боловсруулсан "Арилжааны банкны бүтцийн өөрчлөлт, хувьчлалын талаар Засгийн газраас баримтлах бодлого"-ын төслийг зөвшөөрч Улсын Их Хуралд танилцуулахаар тогтоосугай.

2.Төрийн өмчийн оролцоотой арилжааны банкууд дахь төрийн өмчийн төлөөллийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заасны дагуу хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн хорооны дарга З.Энхболдод даалгасугай.

3.Банкны бүтцийн өөрчлөлтийн явцад хяналт тавьж, төрийн өмчийн оролцоотой банкуудын зээлийн эргэн барагдуулах ажлыг шуурхай зохион байгуулахыг Хууль зүйн сайд С.Батчулуун, Сангийн сайд Б.Батбаяр, Төрийн өмчийн хорооны дарга З.Энхболд нарт даалгасугай.

4."Сэргээн босголтын банкны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1998 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 80 дугаар тогтоолын 1 дүгээр заалтыг "Сэргээн босголтын банкийг санхүү, төлбөрийн чадвар сайтай өөр банктай төрийн өмч давамгайлсан хэлбэрээр нийлүүлэх замаар удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, санхүү, төлбөрийн чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Батбаяр

йн эмчийн хороовы дарга З.Энхболд нарт гасугай" гэж өөрчлөн найруулсугай.

.Нийлсэн /"Сэргээн босголт-Голомт"/ банкны ийн санг төрийн өмчийг давамгайлсан байдлаар гдүүлэх хэлэлцээ хийж, гэрээ байгуулах эрхийг йн өмчийн хороовы дарга З.Энхболдод олгосугай.

.Тус банкны дүрмийн сангийн төрийн өмчийн цоог нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсвийн эх үүсвэрээс гаргахыг Сангийн сайд Б.Батбаярт еерсүгэй.

.Тогтоолын биелэлтийн явцад хяналт тавьж, дүнг оны 8 дугаар сарын 15-ны дотор Засгийн газарт лцуулахыг Сангийн сайд Б.Батбаярт даалгасугай.

Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Сэргээн олтын банкны талаар авах зарим арга хэмжээний й" Засгийн газрын 1998 оны 5 дугаар сарын 27-ны йн 80 дугаар тогтоолын 2, 3 дугаар заалтыг нгүй болсонд тооцсугай.

онгол Улсын Ерөнхий сайд Ц.ЭЛБЭГДОРЖ

ангийн сайд Б.БАТБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

98 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 115 Улаанбаатар хот

**Зээлийн өрийг төлүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай**

нкны зээлийн өрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх агоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Татан буугдсан Ард болон Даатгал банк, үрсан Төв Ази банкны зээлийн өр барагдуулах ажил сирч байгааг харгалзан энэ ажилд хууль, хяналтын уллага болон бусад холбогдох байгууллагуудыг дуулах замаар зээл төлөлтийг эрчимжүүлэх арга эз авахыг Сангийн сайд Б.Батбаяр, Хууль зүйн сайд гчулуун нарт даалгасугай.

Зээлийн өр барагдуулах ажилд оролцох талуудтай э байгууллага, тэдгээрт мөнгөн хэлбэрээр төлүүлсэн йн үнийн дүнгийн 30 хүртэлх хувьтай тэнцэх

хэмжээний урамшуулал олгож байхыг Сангийн с
Б.Батбаярт зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоолын 2 дугаарт заасан урамшууллын д
жил бүр тооцох, тухайн жилийн төсвийн боломж
уялдуулан 1999 оноос эхлэн төсөвт тусгаж бай
Сангийн сайд Б.Батбаярт даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд Ц.ЭЛБЭГД**

**Сангийн сайд Б.БАТБАЯ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

1998 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 116 Улаанбаат хот

**Засгийн газрын тусгай зориулалт сангуудын талаар авах зарим арг хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

